

Баянзүрх дүүргийн Засаг даргын 2018 оны 02 сарын 05 -нь өдрийн А /33 тоот захирамж гарч Өсвөрийн шигшээ багийн төрлүүдэд өөрчлөлт оруулж спортын 12 төрөл болгон баталсан.

Өсвөрийн шигшээ багийн төрөлд:

- |               |   |
|---------------|---|
| 1. Жү-до бөх  | 7 . Спортын гимнастик   |
| 2. Чөлөөт бөх | 8. Даам   |
| 3. Самбо бөх  | 9. Байт харваа  |
| 4. Бокс       | 10. Ширээний теннис   |
| 5. Тэшүүр     | 11. Волейбол  |
| 6. Буудлага   | 12. Сагсан бөмбөг гэсэн спортын төрлөөр үйл ажиллагаа явуулж байна. |

-Өсвөрийн шигшээ багийн багш дасгалжуулагчдын жилийн бэлтгэл сургалтын төлөвлөгөө, шигшээ багийн тамирчдын дэлгэрэнгүй бүртэлийг авч, уралдаан тэмцээнд оролцох хуваарь болон тухайн жилд зарцуулах төсвийн саналыг авч, батлагдсан төлөвлөгөөний дагуу бэлтгэл сургуулилтанд хамруулах ажлыг төлөвлөн ажилласан. Өсвөрийн шигшээ багийн 12 төрөлд нийт 1000 гаруй тамирчин хүүхэд хичээллэж байгаа бөгөөд үүнээс шигшээ багт 192 тамирчинг Дүүргийн аварга шалгаруулах тэмцээн болон бусад шатны уралдаан тэмцээнээс сонгон шалгаруулж бүртгэж авдаг. Үүнээс: Жү-до бөх-28, Самбо бөх-23, Чөлөөт бөх-28, Бокс-13, Тэшүүр-6, Спортын гимнастик-9, Волейбол-28, Ширээний теннис-10, Даам-10, Сагсан бөмбөг-22, Буудлага-7, Байт харваа-8 нийт 192 тамирчин тус тус бэлтгэл сургуулилтад хамрагддаг.

Өсвөрийн шигшээ багийн 12 спортын төрлөөр дүүргийн аварга шалгаруулах тэмцээн явуулахаар төлөвлөсөн боловч Цар тахлын улмаас цуцлагдсан.

2020 оны 10 сард өсвөрийн шигшээ багийн Чөлөөт бөх, Тэшүүр, Даам, Ширээний теннисийн төрлүүдийн тамирчдыг 2021 онд болох Монголын хүүхдийн спортын наадамд бэлтгэх сэргээлтийн бэлтгэлд 7 хоног хамрууллаа. Мөн Тэшүүр, Бокс, Волейбол, Самбо бөх, Ширээний теннисний төрлүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардлыг шийдвэрлэн нийт **15218000** төгрөгийн төсөв зарцуулаад байна.

Шигшээ багийн тамирчид 2020 онд хотын аварга шалгаруулах тэмцээнд Сагсан бөмбөг, Тэшүүр, Ширээний теннис, Волейболоор, Улсын аварга шалгаруулах тэмцээнд Самбо бөх, Тэшүүр, Волейболын төрлөөр оролцон **алт 15, мөнгө 11, хүрэл 24 нийт 50** медаль авлаа.

Корона вирус халдварын хөл хорио нээгдсэнээр шигшээ багуудын бэлтгэл сургуулалт хэвийн үйл ажиллагаанд орон явагдаж байсан ба дахин хөл хорио зарлагдсаны улмаас төлөвлөсөн уралдаан тэмцээн, бэлтгэл сургуулалт бүгд тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон болно.

Нийслэлийн дүүргүүдийн өсвөрийн шигшээ багуудын дунд зохион байгуулагддаг уламжлалт **Чөлөөт бөхийн** эмэгтэй багийн төрлөөр тэмцээн зохион байгуулахаар заавар батлуулсан боловч нөхцөл байдлын улмаас цуцлагдлаа.



## Тэшүүрийн баг тамирчид

Улаанбаатар хотын 2020 оны Гүйлтийн тэшүүрийн аварга шалгаруулах өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээн 2020 оны 1 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд Хандгайтын мөсөн гулгуурийн талбайд болж өндрөллөө. Тэмцээн 9-17 насны 5 ангиллаар зохиогдсон ба хот хөдөөгийн 9 багийн 69 тамирчин оролцлоо.

Үүнээс: 9-10 нас , Охид-Э.Энэрэл –хүрэл, 13-14 нас, Охид-Б.Эмүүжин-Алт, 15-16 нас, Охид-Н.Ширмэнтүяа-алт, 17-с дээш гас, Эмэгтэй-Г.Энхзул-хүрэл, 17-с дээш нас, эрэгтэй- Г.Мөнхэрдэнэ-хүрэл медаль хүртэж байгууллагын дүнгээр 2-р байр эзлэж Мөнгөн медаль хүртлээ.

- Ойрын зайн олон төрөлтийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2020 оны 1 сарын 25-26 –ны өдрүүдэд Хандгайтын мөсөн гулгуурын талбайд болж өндрөллөө. Эмэгтэй, эрэгтэй 500 м- Г.Энхзул- хүрэл, Г.Мөнхэрдэнэ-хүрэл, 1000м- Г.Энхзул, Г.Мөнхэрдэнэ нар –хүрэл медаль хүртлээ.



## Сагсан бөмбөгийн баг тамирчид

“Улаанбаатар лиг” Сагсанбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн 2020 оны 10-р сарын 17-19 хооронд Буянтухаа спорт цогцолборт болж Баянзүрх дүүргийн баг тамирчид амжилт арвин оролцлоо.

Шагналт байранд шалгарсан баг тамирчид

Охидын бага нас

Я.Эрдэнэболор багштай А.Норжин ахлагчтай 44.р сургууль Мөнгө медаль

Хөвгүүдийн дунд насанд

Н.Отгонжаргал багштай А.Болортөгс ахлагчтай 84.р сургууль Мөнгөн медаль

Охидын ахлах насанд

Э.Болорцэцэг багштай Б.Монголжингоо ахлагчтай 33-р сургууль Алтан медаль

Б.Ууганхүү багштай Х.Уянга ахлагчтай 79-р сургууль

Хүрэл медаль

Хөвгүүдийн ахлах насанд

Т.Билгүүн багштай Ц.Нямбат ахлагчтай 48-р сургууль

Алтан медаль

“Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээний ахлах насны охидын ангилалд шилдгийн шилдэг тамирчнаар БЗД-ийн 33-р сургуулийн сурагч Ц.Болорцэцэг, хөвгүүдийн ангилалд шилдгийн шилдэг тамирчнаар БЗД-ийн 48-р сургуулийн сурагч Ц.Нямбат нар шалгарлаа.



### Волейболын баг тамирчид

Волейболын өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээн Завхан аймгийн Улиастай хотод 2020 оны 10-р сарын 21-28-ны хооронд амжилттай зохион байгуулагдаж дуулаа. Д.Өлзийхутаг, Н.Баярсайхан багштай БЗД-ын Өсвөрийн шигшээ багийн "БЗД-Уурхайчин-21" эрэгтэй, эмэгтэй багууд оролцсон ба эрэгтэй баг 30 багаас шилдэг 16-д багтлаа.

Эмэгтэй баг тамирчдийн хувьд: нийт 35 баг тамирчид оролцсон тус тэмцээнээс "Хилчин-хомын тал" багтай аваргын төлөө өрсөлдөж Дэд байранд шалгарч "Мөнгөн" медалийн болзол хангалаа.

Тус тэмцээний Шилдэг холбон тоглогчоор "БЗД-Уурхайчин 21" багийн тамирчин Э. Батцэцэг, мөн шилдэг довтлогчоор М.Энхжин нар тодорсон.



### Бөхийн төрлүүд

2020 оны 10-р сарын 21-23 хооронд спортын төв ордонд Самбо бөхийн 2020 оны өсвөр үеийн Улсын аварга шалгаруулах тэмцээн явагдаж 40 гаруй байгууллагын 530 гаруй тамирчид оролцлоо. Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчдаас мөнгөн медаль 1, хүрэл медаль 2 тус тус хүртлээ.

2020 оны 11 сарын 11-13-нд болсон Самбо бөхийн залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 20 тамирчин оролцуулж, мөнгөн медаль 2, хүрэл медаль 1 авч амжилттай оролцлоо.

МУГТамирчин Д.Нармандахын нэрэмжит жүдо бөхийн өсвөр үеийн олон хотын тэмцээнд нийт 3 насны ангиллаар 1500 гаруй тамирчид оролцож алтан медаль 1, хүрэл медаль 4, авч амжилттай оролцлоо.



### Ширээний теннисний баг тамирчид

Улаанбаатар хотын аварга шалгаруулах ширээний теннисний өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2020 оны 11 дүгээр сарын 05-08-ны хооронд “Оч” клуб дээр баг, ганцаарчилсан гэсэн 2 төрлөөр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд нийт 9 дүүргийн 270 өсвөр үеийн тамирчид оролцож тус тэмцээнээс шалгарсан баг тамирчид 2020 оны өсвөр үеийн Монгол Улсын Аварга шалгаруулах тэмцээнд оролцох юм. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хорооны өсвөр үеийн шигшээ багийн тамирчид нийт алтан медаль 8, мөнгөн медаль 4, хүрэл медаль 4 авч амжилттай оролцлоо.



### Спортын гимнастикийн баг тамирчид

-Баянзүрх дүүргийн өсвөрийн шигшээ багийн гимнастикийн тамирчид ОХУ-ын Благовешинск хотноо болсон Спортын гимнастикийн олон улсын тэмцээнд амжилттай оролцож ганцаарчилсан төрлөөр 2 алт, 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртэж, багийн нийлбэр дүнгээр **Мөнгөн цом** авлаа.



ӨСВӨРИЙН ШИГШЭЭ БАГ

## Сэргээлтийн 7 хоног

2021 онд зохион байгуулагдах Монголын хүүхдийн спортын 7-р их наадмын бэлтгэл ажлын хүрээнд 2020 оны 10 дугаар сарын 20-27-ны хооронд Чөлөөт бөх, Тэшүүр, Даам, Ширээний теннисний баг тамирчдыг 7 хоногийн хугацаатай цугларалт хэлбэрээр бэлтгэл сургалтыг зохион байгууллаа. Энэхүү зохион байгуулалт нь зөвхөн тухайн хугацаанд хичээл болон бэлтгэлийн хооронд амралт, хооллолтыг зохицуулахад зориулагдсан үр дүнгээ өгсөн арга хэмжээ боллоо.






СЭРГЭЛТ



СУРГАЛТ



ХЯНАСАН:

ДАРГА

С.ЭРДЭНЭБАТ

НЭГТГЭСЭН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ю.БАТСАЙХАН